



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



**JAPAN**  
Official Development Assistance



**Save the Children**

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2012 оны 5 сар № 2



**“ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГ” ТӨСЛИЙН  
ГАРААНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ БА  
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**



# СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Японы Хүүхдийг Ивээх Сан  
Улаанбаатар, 2011 он

Тус судалгааг Япон улсын Гадаад хэргийн яамны Японы төрийн бус байгууллагуудыг дэмжих тэтгэлгийн хүрээнд Японы Хүүхдийг Ивээх Сангаас “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийн гарааны нөхцлийг үнэлэх, төслийн явц, үр дүнг хэрэгжилт, эцсийн үр нөлөөг хэмжих суурь үзүүлэлтийг бий болгох зорилгоор 2011 оны 9 дүгээр сарын 14-11 дүгээр сарын 1 хооронд хийж гүйцэтгэсэн юм.

Судалгаанд төсөлд хамрагдаж байгаа Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн 16 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч 30 хүн, 127 багш, 21 туслах багш, 16 цэцэрлэгийн эмч, 81 эцэг эх, асран хамгаалагч нийт 275 хүн хамрагдав. Судалгааны ажилд бүлгийн болон ганцаарчилсан асуулга, ярилцлага, ажиглалтын аргууд ашигласан болно.

Энэхүү судалгааны хураангуйг цаашид Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн загвар бий болгоход гарааны нөхцөл байдлыг тодорхойлоход анхаарах зүйлсийг судлах эх сурвалж болгох үүднээс хэвлүүлж байна.

Судалгааны ажлын явцад цуглуулсан мэдээлэл нь дараах асуудлыг хамаарч байна:

- Төслийн зорилтот цэцэрлэгүүдийн материаллаг орчны үзүүлэлтүүд
- Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн талаарх цэцэрлэгийн эрхлэгчийн мэдлэг, хандлага
- Хүмүүжлийн эерэг аргын талаарх багш нарын мэдлэг, дадлага, ур чадвар
- Цэцэрлэгийн эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэндийн талаарх цэцэрлэгийн эмч, туслах багшийн мэдлэг, дадлага, ур чадвар
- Цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх, хянах Мэргэжлийн хяналтын байгууллагын ашиглаж буй үнэлгээ, хандлага
- Хүүхдийн эрх, бага насны хүүхдийн хөгжил хамгааллын талаарх эцэг эхийн ойлголт, тэдний цэцэрлэгийн үйл ажиллагаан дахь оролцоо, хандлага
- Цэцэрлэгийн удирдлагын үйл ажиллагаанд Эцэг эхийн зөвлөлийн оролцож буй байдал

Төслийн зорилтот дүүргүүдийн талаарх товч мэдээлэл:

Төсөлд хамрагдаж байгаа дөрвөн дүүрэгт нийт 33915 өрхийн 104458 хүн ам оршин сууж байгаа ба 2-5 насны нийт 9901 хүүхэд амьдарч байна. Тэдний 6153 нь цэцэрлэгт хамрагдсан бол 630 хүүхэд СӨБ-ын хувилбарт сургалтаар хүмүүжиж байна. Эндээс үзвэл дөрвөн дүүргийн бага насны хүүхдүүдийн 70 орчим хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. Гэвч цэцэрлэгийн хүчин чадал хүрэлцээгүйгээс хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах боломж бүрдээгүй байна.

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ (ТОВЧИЛСОН ХУВИЛБАР)

### 1. Цэцэрлэгийн багш нар

- Асуулга, ярилцлага, ажиглалтын үр дүнд цэцэрлэгийн анги, бүлгүүдийн хүүхдийн тоо 30-70 хүүхэдтэй, дундажаар 45 хүүхэдтэй байв. Өөрөөр хэлбэл нэг багшид, туслах багшийн оролцохгүйгээр 45 хүүхэд ногдож байгаа нь өндөр үзүүлэлт юм.
- Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарын асуулгад өгсөн хариултаас үзэхэд цэцэрлэгийн үндсэн болон туслах багшийн аль нэг нь байхгүй байх эсвэл өвчтэй тохиолдолд орлон ажиллах багш байхгүй, зохицуулахад хамгийн хэцүү асуудал гэжээ.
- Цэцэрлэгүүдийн хүний нөөц хүрэлцээгүй байдал, багшийн ажлын ачаалал, ажлын онцлогоос шалтгаалан багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах явдал бэрхшээлтэй байна.
- Багш нарын эерэг хүмүүжлийн арга зүйг ашиглаж байгаа байдлыг асуулгын аргаар судлав. Үнэлгээнд 127 багш оролцсноос дөнгөж 13% нь Японы Хүүхдийг Ивээх Сангаас өмнөх төслийн хүрээнд зохион байгуулсан эерэг хүмүүжлийн арга зүйн сургалтанд хамрагдсан байна. Эдгээр багш нар эерэг хүмүүжлийн арга зүйг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа гэж хариулсан бөгөөд дараах арга хэлбэрүүдийг дурдсан байна. Үүнд:
  - Хүүхдийг магтаж, дэмжих, урамшуулах
  - Хүүхэд бүрийн зан харилцаанд тохируулан харьцах
  - Хүүхэдтэй илэн далангүй ярилцах, сонсох
  - Тоглоомын арга ашиглах
  - Хүүхдийн насны онцлогийг харгалзах
  - Хүүхдийг зөнгөөр байлгах
- Багш нар харилцаа, хүүхдийн сурч хүмүүжихэд эерэг хүмүүжлийн арга зүйн ач холбогдлыг ойлгосон байгаа ч хүүхдэд үзүүлэх халамж, үйлчилгээнд энэ арга зүйг ашиглаж байгаа байдлаа тодорхойлоогүй байв. “Эерэг хүмүүжлийн арга зүй” –г ашиглахад хүүхдийн тоо

их, зөрүүд хүүхэдтэй ажиллахад төвөгтэй, хүүхдүүд ихэвчлэн айлын ганц, хоёр хүүхэд байдаг тул их дураараа зантай, хүүхдийн зан авирт гэр бүлийн нөлөөлөл их байдаг гэсэн хүндрэл бэрхшээлүүд гардаг гэсэн хариулыг багш нар тоочжээ.

### 2. Цэцэрлэгийн туслах багш, эмч

- Төсөлд хамрагдаж байгаа цэцэрлэгүүдийн туслах багш, эмч нар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллахад шаардагдах мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх анхан шатны сургалтанд хамрагдсан болон хүүхдийн эмчээр мэргэшсэн эсэхийг судлахад туслах багш нарын 87,1% нь, эмч нарын 16,7% нь хамрагдсан байна.
- Судалгаагаар цэцэрлэгийн туслах багш анги танхимын цэвэрлэгээ хийх, халдваргүйжүүлэх, хүүхдийн асаргаа зэрэг ажлыг голчлон гүйцэтгэж сургалтын материал бэлтгэх болон бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх явдал нь хязгаарлагдмал байна. Ангийн нэг багшид сургалт хүмүүжлийн ажилдаа бэлтгэх, хичээл заах, хүүхэдтэй ажиллах зэрэг хэт их ачаалал ноогдож байна.
- СӨБ-ын тухай хуулиар үндсэн болон туслах багш, эмч нар нарт хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, анги, бүлгийн эрүүл ахуй, орчны ариун цэврийг сахих талаар сургалт явуулах, зөвлөгөө өгөх үүрэгтэй ч эмч нар эрүүл ахуйн хяналт тавих, мөн хоол хүнсний тэжээллэг байдал, аюулгүй байдлыг хангах үүргийг гүйцэтгэж байгаа бол туслах багш нар бүлгийн эрүүл ахуй, цэвэрлэгээг илүүтэй хариуцаж байна.
- МУБИС-ын Сургуулийн өмнөх боловсролын сургууль нь БСШУЯ-ны хүлээн зөвшөөрч, баталгаажсан багшийн ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрүүдтэй. Мөн бага насны хүүхдийн заах арга зүйн болон хүүхдийн хөгжлийн талаар тусгай хөтөлбөрүүд боловсруулан ашиглаж байна. Гэхдээ одоогоор цэцэрлэгийн эрхлэгч, эмч, туслах багш нарт зориулсан баталгаажсан сургалтын хөтөлбөргүй байна. Иймд эдгээр мэргэжилтнүүдэд зориулсан чанарын шаардлага хангасан мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулж ашиглах явдал чухал байна.

### 3. Цэцэрлэгийн удирдлага


Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нараас “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн талаарх ойлголтын талаар тодруулахад хүүхдэд ээлтэй үйл ажиллагаа явуулахад шаардагдах гол хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Үүнд:

- Хүүхдэд таатай, аюулгүй орчинг бүрдүүлэх (Хамгаалал)
- Хүүхдийн эрүүл мэнд, эрүүл ахуйн стандартыг мөрдөх (Халамж)
- Багшийн хандлага, арга барилыг өөрчлөх, чадавхижуулах тасралтгүй тогтолцоо (Нийгмийн хариуцлага)
- Сургалтын орчин үеийн техник хэрэгслээр хангах (Боловсрол)
- Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон тоглоом, наадгайгаар хангах (Боловсрол)
- Ажиллагсдын бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах чадвар (Боловсрол)

Судалгаанаас харахад цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нар “хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн талаарх ерөнхий

Зураг 1. Эцэг эхийн зөвлөлийн талаарх багшийн байр суурь




шаардлагыг ойлгож байгаа ч энэхүү үзэл санааг хэрэгжүүлэх арга зам, шаардлагын талаар нэгдсэн ойлголт, ур чадвар дутагдалтай байна.

### 4. Эцэг эхийн оролцоо

- Судалгааны явцад дүүргүүдээс цуглуулсан мэдээллээр дийлэнх хороодод хүүхдийн эрхийн талаар тодорхой үйл ажиллагааг зохион байгуулж байна. Гэвч эдгээр үйл ажиллагаа нь эцэг эхийн хүүхдийн эрх, халамж, хамгааллын талаарх мэдлэг, үүрэг хариуцлагыг өсгөхөд чиглээгүй байна. Түүнчлэн энэ төрлийн тодорхой сургалтууд ч бага байна.
- Цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийн уламжлалт хандлага нь анги, танхимыг тохижуулах, шаардлагатай техник хэрэгслийг худалдан авах санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг байна. Судалгаагаар ихэнх багш эцэг эхийн зөвлөлийн үүргийг сургалтын таатай орчинг бүрдүүлэх, шийдвэр гаргах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэсэн хариултуудыг өгсөн байв.
- Цэцэрлэгийн эрхлэгчдийн тал хувь нь цэцэрлэгийн стратеги төлөвлөгөөг боловсруулахад цэцэрлэгийн багш, эцэг эхийн оролцоог хангадаг гэж баталсан бол үлдсэн 50 орчим хувь нь хөгжлийн төлөвлөгөөгөө хамтран боловсруулаагүй байна.

Зураг 2. Эцэг эхийн оролцооны талаарх эцэг эхийн байр суурь




- Судалгааны үр дүнгээс харахад цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийн оролцоо хязгаарлагдмал байна. Эцэг эхийн 54 % нь эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд хааяа эсвэл оролцож байгаагүй гэж хариулсан байв. Тэдний 60 хувь цэцэрлэгээс цэцэрлэгээс зохион байгуулдаг спортын арга хэмжээнүүдэд хааяа эсвэл оролцож байгаагүй байна. Үнэлгээний үр дүн эцэг эхийн зөвлөл нь цэцэрлэгийн үйл ажиллагаанд үр дүнтэйгээр оролцож чадахгүй байгаагийн хамт хүүхдийн асуудлаар шийдвэр гаргахад бүрэн дүүрэн оролцдоггүй гэж гарч байна.

## 5. Цэцэрлэгийн орчин


- Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдийг барилга ашиглалт, халаалт, анги тохижилт, гадаад талбайн тохижилт зэрэг шалгуураар үнэлж үзэхэд дараах байдалтай байна.

Зураг 3.



- Судалгаагаар цэцэрлэгүүд барилгын хүчин чадлаасаа 40 хувиар илүү ачаалалтай ажиллаж байна. 4 – 6 хүүхэд суух зориулалтын ширээг ихэнх тохиолдолд 7-8 хүүхэд хуваан хэрэглэж байна.


Зураг 4.



- Судалгаагаар цэцэрлэгийн тоглоом, сургалтын бусад материалын хангамжинд хандах хандлага ихээхэн ялгаатай байна. Үүнд эцэг, эх, асран хамгаалагч нар ерөнхийдөө сэтгэл ханамжтай байгаа бол багш нар илүү их ном, тоглоом шаардлагатай гэж байв.
- Цэцэрлэгийн ангиудад байгаа хүүхдийн номын тоо харилцан адилгүй байв. Цэцэрлэгийн нэг анги дундажаар 15 – 20 байсан бөгөөд бараг номгүй эсвэл 60 – 70 номтой ч анги байна. Ихэнх ном нимгэн хавтастай байгаагаас амархан урагдаж, хуудас нь салдаг гэж багш нар ярьж байв. Өмнө нь ямар нэг төсөлд хамрагдсан цэцэрлэгүүдийн тоглоомын хангалт бусадтайгаа харьцуулахад арай дээр байна. Тоглоомын насжилтын хувьд 1 жилээс хэтрэхгүй байдаг учир тоглоомын хангалтыг жил бүр хийх шаардлага гарч байна.
- Цэцэрлэгт хүүхдийн ном, тоглоом хангалттай эсэхийг асуухад судалгаанд хамрагдсан эцэг эхийн гуравны нэг нь (35%) хүүхдийн номын хангамж маш сайн, сайн, дөрөвний нэг орчим

(24%) нь хүүхдийн тоглоомын хангамж маш сайн, сайн гэж тус тус хариулжээ. Хамгийн өндөр хувь нь хүүхдийн ном, тоглоомын хангалт дунд (29% болон 45%) зэрэг гэж дүгнэсэн байв. Эцэг эхчүүдийн дийлэнх хувь эерэг хариулт өгсөн шалтгааны нэг эдгээр өрхүүдэд байгаа хүүхдийн ном, тоглоомын цөөн эсвэл байхгүй байгаагаас тэд цэцэрлэгийн хүүхдийн ном, тоглоомын хангамжийг сайн гэж үнэлсэн байж болно. Дээрх хариултууд нь эцэг эх, асран хамгаалагчдын хувьд бага насны хүүхдийн халамж, хөгжлийн талаарх мэдлэг хангалтгүйгээс тэд зориулсан тоглоом наадгай, номын талаар ойлголт муу байгааг харуулж байж болох юм. Дээрх асуултанд эцэг эхийн багагүй хувь (22% болон 12%) “мэдэхгүй” хариултыг сонгосон. Өөрсдийн хүүхдийн хүмүүжиж байгаа бүлгийн тоглоом, номын хангамжийн талаар мэдэхгүй байгаа нь олонх эцэг эхийн хувьд цэцэрлэгийн үйл ажиллагаанд дахь оролцоо хангалтгүйг харуулж байна.

**Зураг 5. Цэцэрлэгийн ном, хүүхдийн тоглоом**



- Судалгаанд хамрагдсан багш нарын ихэнх хувь цэцэрлэгийн сургалтын орчинг хангалтгүй гэж үнэлж байв. Сургалтын материал, техник хэрэгслийн хангамж тааруу, цэцэрлэгийн барилга болон инженерийн байгууламжын ашиглалтын нөхцөл муудсан, жорлонгийн суултуур, бусад эд хогшил хүрэлцээгүй, эрүүл ахуйн болон сургалтын орчинтой холбоотой

хүчин зүйлүүд хангалтгүй гэж тэд үзэж байв.

- Дээрхээс суултуур хүүхдийн харьцааг онцгойлон судлахад 16 хүүхдэд 1 суултуур ноогдож байгаа төдийгүй хүүхдийн бус насанд хүрэгчдийн хэрэглэдэг том суултууртай анги, бүлэг ч байгаа нь стандартын шаардлагыг хангахгүй байна.
- Судалгаагаар цэцэрлэгүүдийн 14 хувь нь стандартын бус байранд үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Хан-Уул дүүргийн 46 дугаар цэцэрлэгийн анги нь нэг л том өрөөтэй бөгөөд ариун цэврийн тусгай өрөө байхгүй. Давхар бүрт нэгдсэн ариун цэврийн өрөөтэй байна.
- Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдийн сургалтын тоног төхөөрөмжийн боломж ихээхэн ялгаатай байв. Зарим цэцэрлэг төгөлдөр хуур, компьютер, принтер, хувилах машин (сургалтын материал бэлтгэх зориулалттай) боломжийн түвшинд байхад зарим цэцэрлэгт эдгээр тоног төхөөрөмж байхгүй байна.
- Цэцэрлэгт хүүхдийн ор, зөөлөн эдлэлийн хангамж дутагдалтай талаар олон багш, туслах багш нар танилцуулж байв.

Судалгаагаар төсөлд хамрагдсан цэцэрлэгүүдийн одоогийн нөхцөл байдал нь цэцэрлэгүүд хүчин чадлаасаа хэтэрсэн, ажиллагсдын ачаалал хэт их, түүнчлэн хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн зарчмын талаар цэцэрлэгийн багш ажилчид, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудын ойлголт хангалттай биш, багш ажиллагсдыг ажлын байран дээр хөгжүүлэх тогтолцоогүй, цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулах зохион байгуулалт, хэрэгжилтийн тогтолцоо хангалтгүй байгааг тодорхойлж байна.

Үнэлгээний багийн зүгээс төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Сургалт, эерэг хүмүүжлийн арга зүйг ашиглах хандлагыг нэмэгдүүлэх талаар**

Төслийн хүрээнд эерэг хүмүүжлийн арга зүйн мэдлэг, зохих практикийг багш, туслах багш нарт олгох, түүнийг зөв хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Энэ үйл ажиллагааны үр дүнг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд:

- Эерэг хүмүүжлийн арга зүйн сургалтанд суусан багш, ажилтны тоо
- Эерэг хүмүүжлийн арга зүйтэй холбоотой илэрсэн зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдал
- Эерэг хүмүүжлийн арга зүйг ашиглаж байгаа сайн туршлага
- Эерэг хүмүүжлийн арга зүйг ашигласнаар хүүхдийн хандлагад гарч байгаа өөрчлөлт

### **Хүүхдийн эрүүл мэндийн хяналт үйлчилгээг сайжруулах талаар**

Төслийн хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдийн эрүүл мэндийн хяналтын цогц системийг бий болгоход цэцэрлэгийн оролцоо, хүлээх үүрэг хариуцлагыг оновчтой тодорхойлоход чиглэх нь зүйтэй.

Энэ үйл ажиллагааны үр дүнг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд:

- Цэцэрлэгийн эмчийн чиг үүрэгт хүүхдийн эрүүл мэндийн хяналт, эрүүл мэндийн үйлчилгээний талаар орсон шинэ үйл ажиллагааны тоо
- Хүүхдийг эрүүлжүүлэх, хянах систем, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн картын ашигласан байдал
- Эрүүл мэндийн хяналт, эрүүл мэндийн боловсролын талаар эрхлэгч, үндсэн болон туслах багш, бусад ажиллагсад болон эцэг эхийн чадавхийг хөгжүүлсэн байдал
- Хүүхдийн эрүүл мэндийн зөв дадал, хэвшлийг эзэмшсэн байдлын үнэлгээ зэрэг болно.

### **Нээлттэй байдал, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх талаар**

Төслийн хүрээнд эцэг эхийг чадавхижуулах замаар бага насны хүүхдийн төлөө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцох боломж, хэлбэрийг илүү үр дүнтэй болгох шаардлагатай юм.

Энэ үйл ажиллагааны үр дүнг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Сургалтанд хамрагдсан эцэг эхийн тоо
- Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа, чиг үүрэгт гаргаж байгаа өөрчлөлт

### **Хүүхдийн хөгжих, хүмүүжих аюулгүй орчинг бүрдүүлэх талаар**

Төслийн хүрээнд хүүхдийн хөгжих, хүмүүжих аюулгүй орчинг хангахад ариун цэврийн байгууламжийн хүртээмж, багшийн заах болон харилцааны ур чадвар, сургалтын материалын хүртээмж зэргийг сайжруулах, нэмэгдүүлэхэд анхаарах нь чухал юм.

Цэцэрлэгийн бүлгийн ачаалал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд ариун байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтэнд зарцуулах цаг хугацааг багасгах замаар туслах багш үндсэн багшид дэмжлэг үзүүлэх боломж нэмэгдэнэ. Мөн үндсэн багш сургалтын материал бэлтгэх боломжийг нэмэгдүүлэх, олшруулах, бэлэн материал ашиглах нөхцөл бүрдсэнээр хүүхэдтэй ажиллах, хүүхдийн хөгжил, хүмүүжил, эрүүл мэндэд зарцуулах цаг хугацаа нэмэгдэнэ.

Энэ үйл ажиллагааны үр дүнг дараах байдлаар тодорхойлох боломжтой. Үүнд

- Нэг суултуур болон дөрөв болон зургаан хүүхэд суух зориулалттай нэг ширээнд ноогдох хүүхдийн тооны өөрчлөлт
- Ариутгал, халдваргүйжүүлэлтэнд долоо хоногт туслах багшийн зарцуулсан цаг хугацааны өөрчлөлт
- Туслах багшийн чиг үүрэгт гарсан өөрчлөлт
- Сургалтын материал бэлтгэхэд зарцуулж байгаа цаг хугацаанд гарсан өөрчлөлт
- Үндсэн болон туслах багшийн ганцаар ажилласан цаг хугацаа зэрэг болно.

## Судалгааны үр дүнг төслөөс тавьж буй шалгуур үзүүлэлтэй харьцуулсан хүснэгт

Төслийн шалгуур үзүүлэлт	Судалгааны үр дүнд гарсан суурь утга
Цэцэрлэгийн багшийн 70% нь хүүхдэд ээлтэй цэцэрлэг, эерэг хүмүүжлийн арга зүйн мэдлэгтэй болж, түүнийгээ практикт ашигладаг болно.	Судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн багш нарын 13% нь хүүхдийн эерэг хүмүүжлийн арга зүйн сургалтад хамрагдсан түүнийгээ ажилдаа хэрэглэх мэдлэг олж авсан гэж хариулсан байна.
Туслах багшийн болон цэцэрлэгийн эмчийн 50% нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн талаар ойлголттой болж, багш нартай хамтран эл зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцоно.	Судалгаанд хамрагдсан туслах багш нарын 14% нь сертификатын сургалтад хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан ихэнх эмч нарын хувьд тусгайлан энэ талын сургалтанд хамрагдаагүй байна. Бага насны хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн талаар эмч, туслах багш нарын ур чадвар дутагдалтай байгаа нь ангийн багшид хангалттай дэмжлэг үзүүлж чадахгүй, улмаар үйлчилгээний чанарт нөлөөлөх шалтгаан болж байна.
Цэцэрлэгийн эрхлэгчийн 70% нь “хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн зарчмын талаар илүү ойлголттой болсон байна.	Цэцэрлэгийн эрхлэгч нар “хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн талаар ерөнхий ойлголттой байгаа ч энэ үзэл санааг хэрэгжүүлэх арга замын талаарх нэгдсэн ойлголт, чадвар хангалтгүй байна.
Цэцэрлэгийн 50% нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн сайн засаглалыг практикт хэрэгжүүлнэ.	Судалгааны үр дүнгээс үзэхэд цэцэрлэгүүдэд эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, эцэг эх гэр бүлийн ухамсартай оролцоо бий болгож хамтран ажиллах, хүүхдийн төлөө сайн багш, хамт олныг бий болгох зорилготой байгууллагын нэгдмэл төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний цогц ойлголт, удирдлагын арга барил, чадварыг бэхжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.
Улсын болон нийслэлийн мэргэжлийн газрын байцаагчидтай хамтран хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үнэлгээний систем, гарын авлага боловсруулж, үүнд нийцсэн хамтын ажиллагаа, цэцэрлэгийн өөрийн үнэлгээний туршлага бий болгоно.	Судалгаанаас үзвэл орон нутгийн мэргэжлийн хяналтын газраас хийгдэж буй хяналт шалгалтууд холбогдох хууль, стандарт журмын дагуу явагдаж байгаа ч цэцэрлэг, хяналтын байцаагчийн хамтын ажиллагааг сайжруулах, тэдний мэргэжлийн зөвлөгөө тусалцааг нэмэгдүүлэх, цэцэрлэгийн үйл ажиллагаа, орчныг “хүүхдийн эрүүл аюулгүй байдал, эрх”-д суурилсан үнэлгээний цогц систем боловсруулж хэрэгжүүлэх, цэцэрлэгүүдийн өөрийн үнэлгээний чадавхийг сайжруулах туршлага хэрэгтэй байна.
Эцэг эх, асран хамгаалагчдын 50% нь хүүхдийн эрх, эцэг эхийн үүрэг хариуцлагын тодорхой ойлголттой болж, хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга зүйг ашиглах хүсэл эрмэлзэлтэй болсон байна.	Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, хүлээх хариуцлага хязгаарлагдмал, гагцхүү уламжлалт хэлбэр болох орчинг тохижуулах, хуралд оролцох хэлбэрийн оролцоо зонхилж байна. Мөн дийлэнх эцэг эхчүүд хүүхдийнхээ өсөлт хөгжил, эрүүл мэндийн талаарх мэдээллийг цэцэрлэг, багшаас түлхүү авахыг хүсдэг гэж хариулжээ.
Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн 50% нь цэцэрлэгийн удирдлагад дуу хоолойгоо хүргэх замаар эерэг нөлөөллийг үзүүлнэ.	Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 54 % нь эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд хааяа эсвэл оролцож байгаагүй гэж хариулсан байв. Мөн эцэг эхчүүдийн дийлэнх нь багшаас хүүхдийнхээ талаарх мэдээллийг авдаг, тэдний зохион байгуулсан ажлуудад л ихэнхдээ оролцдог гэж хариулжээ. Иймд ихэнх цэцэрлэгийн хувьд эцэг эх, гэр бүлийн гишүүдийн оролцоог идэвхжүүлэх, тэдний сайн дурын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна.
Зорилтод цэцэрлэгийн 50% -д хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдэд багш нар ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх нөхцөлийг хангах, хүүхэд эрүүл, аюулгүй хөгжиж байх орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.